



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 423

Улаанбаатар хот




“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ”
төрийн өмчит хувьцаат компанийн
2018 оны төлөвлөгөөг өөрчлөн
батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6.10.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 677 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хавсралтад заасан хөрөнгө оруулалтыг нэмсүгэй.

2. Компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан 2018 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авалтын төлөвлөгөөнд зохих өөрчлөлт оруулан баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА 
ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА 
Ц.НЯМ-ОСОР
Б.ГАВАА 

0002205

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

"ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2018 ОНЫ
ИХ ЗАСВАР, ТЕХНИК ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД
НЭМЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Батлагдсан төсөвт өртөг (мян.төг)	Дүн (мян.төг)
1. ИХ ЗАСВАР			
1	Гурвантэс сумын нутагт байрлах Чинхуа-Мак нарийн сухайт ХХК-н 35/6 кВ-ын дэд станцаас 35 кВ-н салбарласан элегаз таслуур, хүчдэлийн трансформатор, гүйдлийн трансформаторуудыг иж бүрэн шинэчлэх	-	50,190.9